

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр, Лхагва гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-2

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 3-11

---

1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 3-11

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
11 дүгээр сарын 20-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 39 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Болормаа, Х.Жангабыл, Б.Жаргалан, Н.Наранбаатар, Ж.Энхбаяр;  
Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Б.Дэлгэрсайхан, Н.Номтойбаяр, П.Сайнзориг, Б.Энхбаяр.

**Нэг.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Пүрэвдорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, мөн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ, “Мон-Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн Геологи, уул уурхайн албаны ахлах инженер А.Алтанхундага, Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга Ж.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, “Мон-Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т заасны дагуу Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Пүрэвдорж саналаа тайлбарлав.

**Г.Тэмүүлэн:** Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.5 дахь хэсгийн “энэ хуулийн 34.6-д заасан журмын дагуу тооцож, төрийн дансанд байршуулна.” гэснийг “олон улсад нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн хэрэгсэл, эс үгүй бол Монголбанк дахь валютын тусгай дансанд байршуулах бөгөөд гагцхүү зориулалтын дагуу ашиглана.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 6  
Бүгд: 15  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 28 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 07 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
13 цаг 39 минут.

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна.

Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Батын Батбаатар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2024 оны 11 сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг асуудал байгаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл. Засгийн газар 10 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг байгаад байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

**Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Ажлын хэсгийг хуралдаанд оруулъя.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд бичгээр тараасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, ЗГХЭГ-ын дэд дарга Дорждэрэмийн Цолмон, Монголбанкны дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Нармандахын Жамъянхүү, Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Туулхангайн Ганбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Усны газрын дарга Зинэмидэрийн Батбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Баатарын Мөнхтогтох, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Гунаажавын Манлайжав, тус комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Энхгэрэлийн Нямдаваа, “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал Санжаагийн Наранцогт, “Эрдэнэс Монгол” компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Балжиннямын Гэрлээ, СЗХ-ны Хууль, эрх зүйн газрын дарга Жаргалсайханы Мөнх-Оргил, Мон-Атомын гүйцэтгэх захирал Доржбалын Далайжаргал, тус компанийн Геологи, уурхайн албаны ахлах инженер Амарсайханы Алтанхундага, тус компанийн Захиргаа удирдлагын албаны дарга Дашдаваагийн Сугарсүрэн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэнтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Ганбат гишүүн. Ганбат гишүүнээр тасалъя.

Ганбат гишүүн асуултаа асууна.

**Д.Ганбат:** Ингээд та бүхнийхээ амар амгаланг айлтгая. Ингээд энэ хууль яаралтай горимоор орж ирээд, өнөөдөр манай Байнгын хороо дээр эцсийн хэлэлцүүлэг ингээд явагдаж байна. Энэ дээр хэд хэдэн тодруулах зүйл надад байна. Хэдийгээр ингээд явж байгаа боловч.

Энэ хууль хэрэгжээд батлагдсаны дараа, хэрэгжих үедээ хэзээ үр дүнгээ өгч эхлэх вэ? Нэлээн яаралтай горимоор орж ирлээ шүү дээ. Ингээд баталчихлаа. Энэ их олон жил явж байгаа. Үр дүн нь хэзээ гарах юм бэ?

2 дугаарт, энэ юу байна аа, цаанаас ашиглалтын зөвшөөрөлтэй хэд хэдэн компани байна. Тэргүүн ээлжид Францын Рона компани орж ирэх юм шиг байна. Энэ бэлэн болчихлоо гэж бодож байгаа. Их олон дарга нар айлчилсан. Тэгээд энэ айлчлал, энэ гэрээ хэлэлцээний үр дүн нь гарахдаа энэ Рона компани чинь яг ямар компани юм бэ. Тэрийгээ өөрөө илэрхийлсэн үү. Баталгаажуулж. Тэр бичиг баримтыг нь авсан уу. Рона компани маань хамгийн тэргүүний техник, технологи хэрэглэж энэ ашиглалтыг хийнэ гэсэн ийм баталгааг нь авах хэрэгтэй. Уул уурхай ямар нэгэн мөрөө үлдээж таарна. Мэдээж хэрэг тэр ямар нэгэн байгаль орчинд хор хөнөөл үзүүлдэггүй тийм уул уурхай гэж хаана ч байхгүй. Зүгээр хамгийн тэргүүний техник, технологи энийг ашиглаж хийнэ гэсэн баталгааг нь авах хэрэгтэй. Тэр компани нь яг өөрийгөө илэрхийлэх ёстой. Тэр эзэмшигчид нь хэн хэн байдгийг оруулах ёстой.

Миний ойлгож байгаагаар Японы Мицубиши компани бас орчихсон явж байгаа байх. Энэ.

Нөгөөдөх нь нэг заалт байх ёстой. Юу гэхээр, энэ гарч байгаа уран өөрөө энх тайвны зорилгод ашиглагдах ёстой. Нөгөө талаар энэ уранаас гарч байгаа 50

хувийг нь бид өөрсдөө мэдэж борлуулах эрхтэй үлдэх ёстой. Энэ цаашдаа бид нарт маш их хэрэгтэй.

3 дугаарт, Францтай бид иргэдээ харилцан визгүй зорчих ийм эрхийг нь нээж өгөх хэрэгтэй. Хажуугаар нь. Тэгвэл Европын Холбооны улсад манай иргэд цаашдаа харилцан визгүй зорчдог болно оо. Энэ гэрээг дагалдуулаад ийм дэвшил, ийм зүйлүүдийг хийчих хэрэгтэй. Энэ протоколдоо тусгачхаарай. Миний юу хэлж ярьсан, юу гэснийг. Ийм юмыг чиглэл болгож ажиллах хэрэгтэй. Ажиллаж байгаа юу, үгүй юү?

Ер нь тэгээд нэг иргэддээ ээлтэй, иргэддээ хэрэгтэй тэр бодлогууд хамгийн түрүүнд хоцордог шүү. Энэ юмаа хийчих юмыг та нар ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Эцсийн хэлэлцүүлэг уг нь танилцуулгатай холбогдуулж асуулт асуух байгаа. Гэхдээ Ганбат гишүүний асуултад хариулна. Туваан сайд асуултад хариулах уу? Туваан сайдын микрофоныг өгье.

**Ц.Туваан:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Тийм, энэ яаралтай горимоор оруулж ирсэн. Тэгээд оруулж ирсэн нь нөгөө энэ Та өөрөө хэллээ. Энэ хэлэлцэж яригдаж байгаа асуудал маань энэ Хөрөнгө оруулалтын гэрээний асуудал маш он удаан жил яригдаж байгаа. Тэгэхээр энэ дээр бид бүхэн 2 улс дээд түвшиндээ уулзалт хийгээд, ингээд олон удаа ярьчихсан учраас үүнийг ондоо багтаах чадвал, чадахгүй бол 1 сардаа багтаах гэсэн ийм байдлаар нэлээн яаравчилж байгаа.

Тэгээд мэдээж хууль, энэ хууль батлагдаад, энэ хуульд гаргаж өгч байгаа энэ боломж шүү дээ, энэ чинь одоо нөгөө нэг энгийн хувьцааг давуугаар солих, мөн 34 хувийн үнэгүй хувьцааг тусгай АМНАТ-аар солих гэсэн ийм л боломжуудыг нээж өгч байгаа.

Тэгэхээр ийм байдлаар явж байгаа. Мэдээж үр дүн ойрын хугацаанд гарах ийм гарвал Монгол Улсад ашигтай. Тэгэхээр үүнийг хууль батлагдаад хөрөнгө оруулалтын гэрээ бас удахгүй Их Хурлаар үүний дараа орж ирнэ. Тэр үед бид нар нэлээн тодорхой ярилцах ийм боломж гарна. Тэгээд 3 жилийн хугацаанд энэ шар нунтгийг гаргаж эхлэх ийм хугацаа байгаа.

Францын Рона компани мэдээж яг энэ салбартаа дэлхийд тэргүүлэх компаниудын нэг. Манай Монголын Мон-Атом компанийн 34, Ронагийн 66 хувьтай нийлсэн Бадрах Энержи гэдэг компани байгуулаад энэ хөрөнгө оруулалтын гэрээ 2 талаасаа ажлын хэсэг ингээд ажиллаад явж байгаа гэдгийг хэлье.

Энэ ашиглаж байгаа технологи бол дэлхийд 52-60 хувьд нь ураны олборлолт дээр ашиглаж байгаа, газар доор уусган олборлох гэдэг энэ технологийг ашиглаж байгаа. Энэ яг манай энэ Зөөвч-Овоо ордод хамгийн тохирсон ийм технологи оо гэдгийг манай албаныхан ч хэлж байгаа, бид бүхэн ч гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгийг хэлье.

Мэдээж дэлхийн зах зээл дээр ураны эрэлт эрс нэмэгдэж байгаа. Тэгэхээр нийлүүлэлтийн хувьд жоохон хомсдол үүсэж байгаа. Тэгэхээр энэ манай Монголоос олборлогдох ураны хэмжээ, ураны үнэ нэмэгдэх, үүнийгээ дагаад эдийн засгийн ач холбогдолтой болох ёстой.

Тэгээд мэдээж үүнийг цөмийн эрчим хүч үйлдвэрлэх хамгийн бага хүлэмжийн хий үйлдвэрлэдэг эрчим хүчний реакторуудад ашиглах зорилгоор энэ ашиглана гэсэн ийм зүйлтэй явж байгаа. Манайх энэ юун дээр бүтээгдэхүүн хуваах байна уу, энэ юун дээр тэр нэг шар нунтгаас манайх яаж болох дээр нэг тодруулга өгчхөөч. Хувьдаа яаж авах юм. Нөгөө үйлдвэрлээд гарч байгаа шар нунтаг Ганбат гишүүний асуултад ярьсан.

Гадаад яамныхантай 2 улсын иргэдийн харилцан визгүй зорчих асуудлыг энэ хэлэлцээрийн шатад, энэ хөрөнгө оруулалтын гэрээний явцад оруулж болох уу гэдэг зүйлийг тавьчихсан байгаа. Тэгээд яг эцсийн хариу ирээгүй байна. Хөрөнгө оруулалтын гэрээ орж ирэх үеэр энэ асуудлыг би тодорхой хариуг Ганбат гишүүнд өгье.

Нөгөө бүтээгдэхүүн хуваах гэдэг нэг юм чинь яг яаж явах вэ. Манайхан яаж ойлгож байгаа юм. Далайжаргал 2-ыг өгчих дарга аа.

**Г.Тэмүүлэн:** Нэмж хариулъя 2 номер. Далайжаргал.

**Д.Далайжаргал:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Францын Рона групп дэлхийд 2-т, нийт уран олборлолтоороо 2-т ордог, дэлхийн эхний 2-т ордог компани байгаа. Их бүхэлдээ 90 хувь нь төрийн өмчит Францын төрд харьяалагддаг. Та зөв хэлсэн. Япон байдаг 5 хувь нь Японы Мицубиши компани эзэмшдэг. Бас ахиад 5 хувийг нь Японы уран баяжуулдаг төрийн өмчит нэг компани байдаг. Тэр эзэмшдэг бас юм.

Өнгөрсөн 2 улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр төрийн эзэмшлийн 34-ийг татгалзаад, өсөн нэмэгдэх АМНАТ, Тусгай АМНАТ гээд түүгээр орлуулсан. Бид нар 10 хувийг нь захиран зарцуулах эрхээ бид нар эдэлж байгаа юм. Одоо энэ хөрөнгө оруулалтын гэрээгээр бид нар 10 хувиа бид нар бүтээгдэхүүнээ зарах тэр эрх нь оногдож байгаа юм. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүн нэмж тодруулъя. Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** 3 тодорхой зүйл л би яриад байгаа юм л даа. Тэр хууль дээрээ тэр энх тайвны зорилгоор ашиглана гэдэг тэр зүйлийг заалтыг заавал оруулах хэрэгтэй шүү. Тэгэхгүй байж байгаад ямар нэгэн цөмийн цохилтын бай болж болохгүй шүү, 1.

2. Тэр гарч байгаа бүтээгдэхүүн, нөгөө шар нунтгийнхаа 50 хувийг бид нар борлуулах эрхтэй байх ёстой шүү. Түүнийг хуульд оруулж өгөх ёстой.

3-д нь, хамгийн тэргүүний технологи ашигладаг тэр лицензээ гаргах ёстой, баталгаажуулах ёстой. Тэр ямар компанийг нь бид нар мэднэ л дээ. Гэхдээ тэрийг нь авах ёстой гэж л хэлээд байна шүү дээ.

Эцэст нь энэ юмаа ойлгуулахын тулд Франц Монголын найрамдалт харилцааг нөгөө Францчууд маань илэрхийлээд, Монголчуудыг визгүй, харилцан визгүй зорчдог энэ юмыг эхнээсээ хийчих хэрэгтэй. Тэгвэл бид нар чинь ард түмэндээ зөв ойлгуулж болж байна шүү дээ. Тийм.



**Г.Тэмүүлэн:** Нэмж тодруулах уу, хариулах уу? 4 номер Намчинсүрэн.

Ганбат гишүүний асуултад нэмж хариулъя. Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яам Намчинсүрэн.

Яах вэ, энэ цөмийн энергийн хууль маань өөрөө бол Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна гэсэн ерөнхий бол хуулийн зорилт байгаа.

Ер нь та түрүүн хэлж байна. Энэ тэргүүний техник, технологи гээд. Энэ дээр бол цөмийн энергийн хууль дээр цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрөө тэргүүний техник технологитой байх, санхүүгийн чадавхтай байх, олборлох, боловсруулах, олон жилийн туршлагатай байх, цөмийн энэ технологи нэвтрүүлэх чадвартай байх гэх мэт зохицуулалтуудыг, шаардлагуудыг хангасан байж байж, ашиглалтын тусгай зөвшөөрөл авах бол хуультай байгаа.

**Г.Тэмүүлэн:** Бүтээгдэхүүн хуваах. Хэн хариулах вэ? 4 номер.

**Г.Намчинсүрэн:** Яг сая Ерөнхийлөгчийн протокол зурагдахаас өмнө бол Хувь нийлүүлэгчдийн гэрээгээрээ манайх 34 хувийг эзэмшихээр зохицуулалттай байсан. Одоо бол сая Далайжаргал захирал ч хэллээ. Үндсэндээ бол давуу эрхийн 10 хувийн хувьцаа эзэмшиж байгаа. Энэ хүрээндээ 10 хувийн бүтээгдэхүүнийг захиран зарцуулах эрхтэйгээр явж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

**Н.Батсүмбэрэл:** Энэ уг нь энэ Цөмийн энергийн тухай хууль гээд, хууль яваад байгаа. Гэтэл хэлэлцүүлгийн явцад заримдаа харахаар Рона гээд компанитай байгуулах гэж байгаа гэрээ яриад байгаа ч юм шиг болчхоод байгаа.

Тэгэхээр энэ ажлын хэсэг, салбарын яам, тэр Мон-Атом компани энэ мэдээлэл өгөх. Нийтийг мэдээлэлжүүлэх ажлаа сайн хиймээр байна. Их Хурлын гишүүн хүртэл өөрөө төөрөлдсөн байна шүү дээ. Энэ чинь ерөнхий хууль явж байна. Миний ойлгоод байгаагаар. Монгол Улсад нэг 10 гаруй орд байдаг юм шиг байгаа юм. 10 гаруй ордын 1-ийг нь тэр Францын компанитай Монголчууд хамтарч ашиглах тухай ярих гээд хуулиа түүнд эднийхээ бас урьдчилсан байдлаар хэлэлцүүлэг өрнүүлж, өөрчилж байгаа гэж ойлгоод байгаа юм.

Гэтэл энэ хэлэлцүүлэг маань өөрөө тэр тал руу яваад байгаа. Тэгэхээр энэ байгууллагууд энэ, энэ нийтийг мэдээллээр хангах, зөв ойлголт өгөх ажлыг сайн хийх хэрэгтэй байна. Үүнийг та хэд хийгээч гэдгийг захиж хэлмээр байна.

Манлайжав дарга ирчихсэн байна. Би Манлайжав даргаас тэр чуулган дээр Ганбаатар гишүүн нэг юм яриад байсан, тэрийг тодруулж хэлээч гэж би асуумаар байгаа юм. Тэр өмнө нь Цөмийн энергийн газраас нэг бичиг өгсөн юм гэнэ лээ. Тэр ямар учиртай юу явсан юм, тэрийг олон түмэн мэдэх нь зөв байх. Ялангуяа Их Хурлын гишүүд энэ холбогдох Байнгын хорооны гишүүд нь.



Дээр нь энэ эрдэмтэн мэдлэгтнүүд нь юмаа ярихгүй болохоор эрдэм мэдлэггүйнүүд нь дээр гараад юм ярьдаг юм гэнэ лээ гэж хуучны үг байдаг. Танин мэдэхүйн ажлаа сайн хийхгүй болохоор энэ чинь нөгөө бүгдээрээ химич, физикч болоод байна шүү дээ. Тэгэхээр энэ ажлыг манай холбогдох байгууллагууд маань хиймээр байна аа, Тэгшбаяр доктор, энэ тэр бас ингэж өгөхгүй бол зурагтаар гараад юм яриад байгаа Их Хурлын гишүүд маань өөрсдөө хууль ч яриад байгаа ч юм шиг, хэлэлцээр хийгээд ч байгаа ч юм шиг, гэрээ дүгнээд байгаа ч юм шиг байдалтай болчихоод байдаг. Энэ нь өөрөө хэлэлцүүлэгтээ ч хортой, олон нийтэд төөрөгдөлтэй, улс хоорондын хамтын ажиллагаанд ч уршигтай юм болж таарах вий. Үүнийг холбогдох яам, холбогдох байгууллагууд нэлээн анхаарч ажилламаар байна. Ер нь тэгээд энэ чиглэлээр болохгүй бол гишүүдэд зориулсан сургалт хийсэн ч болохгүй юм байхгүй шүү дээ. Ажлын хэсгийн гишүүнд, ажлын хэсэгт би орж ажилласан. Тэгээд энэ чинь мэддэггүй юм байна шүү дээ, хараад байхад. Бид нар юугаа мэдэх вэ.

Тэгээд урд байсан ах нар маань мэддэггүй юм байна. Яг би түрүүн хэлдгээр би бас ингээд төөрөлдөөд гэрээ яриад байна уу, хууль яриад байна уу, хэлэлцээр хийгээд байна уу, ойлгохоо больчихоод л сууж байна. Чухам яг алийг нь яриад байгаа юм?

**Г.Тэмүүлэн:** Батсүмбэрэл гишүүний асуултад Манлайжав дарга хариулах уу? 8 номер.

Батсүмбэрэл гишүүний асуултад товчхон хариулъя. Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга Манлайжав.

Өнгөрсөн Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр Ганбаатар гишүүн энэ зарим мэдээллийг гаргаж тодруулж асуусан байна лээ. Тэгэхээр бид нар бол энэ 2015 оны 6 сард Эдийн засгийн байнгын хороо дээр мэдээлэл хийж байсан. Тэр Ганбат гишүүн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос хүсэлт тавиад мэдээлэл хийсэн гэж, би ойлгосон. Тэгэхдээ энд Эдийн засгийн байнгын хороонд бид нар мэдээлэл хийж байсан юм байна лээ. Энэ үед болохоор тэр үед ураны төсөл, хөтөлбөрүүдийн талаар ерөнхий мэдээлэл өг гэж Байнгын хорооноос хүсэлт тавьсны дагуу мэдээлэл хийсэн. Энэ дээр Бадрах Энержи компани тэр үед Гурван сайхан компани, Эмээлт Майнс гэсэн ийм 3 компанийн манай дээр байгаа ТЭЗҮ-үүдийг нэгтгээд, эндээс тэр үед байсан ТЭЗҮ дээр бол анализ хийж гаргасан. Энэ дээр АМНАТ-ыг ТЭЗҮ дээр Бадрах Энержи компани 9,5 хувиар тооцож өгөхөөр бол эд нар тавьсан байсан. Одоо та нар ингээд буулгаад, суурь АМНАТ-аа 5 болголоо гэж бол тийм ташаа мэдээлэл өгч байна лээ. Одоо бид нар хуулийн төсөл дээр орж байгааг та бүхэн сайн мэдэж байгаа. Суурь АМНАТ бол 5, тусгай АМНАТ бас 5, өсөн нэмэгдэх АМНАТ бол үнэ, борлуулалтын өртгөөс, үнээс хамаараад бол ингэж өсөж байгаа.

Тэгэхээр бид нар бол доод талдаа өнөөдрийн байдлаар 14, түүнээс дээшээ ийм хувьтай АМНАТ-ыг өгөх асуудал байгаа юм. Тэгэхээр энийг би маргааш Ганбаатар гишүүнд энэ талаар албан тоотоос хариу өгье гэж бодож байгаа юм.

Түрүүн Ганбат гишүүний асуусан асуулт дээр нэмж хэлье. Тайлбарлахад тэр энхийн зорилгоор ашиглах асуудал бол манай Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрүүд дээр нэлээд туссан. Манай энэ хөрөнгө оруулалтын гэрээний төсөл дээр хамгийн түрүүнд энэ заалтыг тавьсан байгаа.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, тэрнээсээ Олон улсын атомын энергийн агентлагтай байгуулсан цөмийн зэвсэг үйлдвэрлэх гэрээ болон гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой баталгааг хэлэлцүүлэх хэлэлцээр, тэрний протоколын дагуу бол 2 улс ажиллана. Монгол Улс бол, Бүгд найрамдах Франц улс Монгол Улс хоёулаа олон улсын атомын энергийн гишүүн орон. Энэ гэрээний бол талууд. Тэгэхээр энд бид нар гэрээг үүний бас нэмэлт протоколыг мөрдөж ажиллаж байгаа. Өнгөрсөн жил гэхэд Олон улсын атомын энергийн агентлагаас энэ Дулаан уул орд дээр Зөөвч-Овоо орд дээр үйлдвэрлэлийн туршилтаа гаргаж авсан. 10,4 тонн шар нунтаг ураныг бол баталгаажуулахаар Инс, олон улсын байцаагч нар ирж ажилласан. Тэд нар тодорхой дүгнэлтүүдээ гаргасан байгаа. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Туваан сайд нэмж хариульъя.

**Ц.Туваан:** Батсүмбэрэл гишүүний асуулт маш чухал асуудал. Энэ нөгөө мэдээлэл өгөх, хүүхдүүдэд ч тэр, ард иргэдэд ч тэр мэдлэг олгох гэдэг асуудал маш чухал байгаа. Энэ тал дээр яах вэ, бас энэ сурталчлан таниулах ажил санхүүтэй л холбоотой байгаад байгаа юм. Тэгээд компанийн зүгээс бид нар яах вэ яг энэ салбарын асуудал ярьж байгаа учраас сайн хараад байгаа юм уу, ер нь хийгээд л байгаа. Тэгэхдээ үүнийг өшөө илүү эрчимжүүлэх шаардлагатай. Ялангуяа энэ Бадрах Энержи компани, энэ Отгонбаяр захирал энэ тэртэй бид нар уулзаж, энэ талын асуудлуудыг нэлээн тавьсан. Тэгэхээр энэ асуудал нэлээн эрчимжээд явна гэдгийг танд хэлье.

Мөн манайтай яг адилхан ойролцоо нөхцөлтэй, бараг хөрш шахуу оршиж байгаа энэ Казакстан улсад яг энэ төсөл, уран олборлох, мөн эрчим хүчний чиглэлээр ашиглах гэдэг энэ асуудлууд байгаа. Тэгэхээр энэ тал дээр цаашдаа анхаараад ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Батсүмбэрэл гишүүн нэмж тодруульъя.

**Н.Батсүмбэрэл:** Тэр, ингэмээр юм шиг харагдаад байгаа юм. Энэ Цөмийн энергийн тухай хуульд ийм ийм заалт, тэдэн заалт өөрчлөлт орлоо, нэг. Цөмийн энергийн хуулийг дагаад ийм 3 хуульд өөрчлөлт орлоо, 2. Энэ асуудлыг нийтэд ил тод мэдээлмээр байна. Яг өнөөдрөөс эхлээд. Ингэхгүй бол нэг юм нууж хийх гээд байгаа юм шиг болчихоод байна. Нэг хэдхэн хүн ард түмний баатар, нэлээн хэдэн нэг тийм урвагч дайсан болчих гээд байдаг, 1 дүгээрт.

2 дугаарт, саяын яриад байгаа энэ физик, химитэй холбоотой сургалтуудыг сайжруулах хэрэгтэй. Тэгэхгүй тэгээд энэ чинь бүгдээрээ мэдэхгүй мөртөө мэдлэгтнүүдийн дүрээр ороод, очоод явж байгаа ажилд нь саад болчихоод байдаг. Энэ цонхыг бид нар ашиглах уу, үгүй юү гэдэг асуудал руу л орох гээд байна шүү дээ.

**Г.Тэмүүлэн:** Санал хэллээ гэж ойлголоо.

Эрдэнэбүрэн гишүүн асуулт асуух болсон уу.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэнтэй холбогдуулаад гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын чуулганаас, хуралдаанаас хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.5 дахь хэсэгт анхны хэлэлцүүлэг явуулахад бол зарчмын зөрөөтэй саналын томьёолоор санал хураалгуулахгүйгээр энэ заалтыг буцааж, гүйцээн боловсруулах чиглэлийг бол өгсөн байгаа. Ингээд байнгын хороонд шилжүүлсэн.

Энэтэй холбогдуулаад 34.5 дахь хэсгийг гүйцээн боловсруулах чиглэлээр бол нэр бүхий гишүүд зарчмын зөрөөтэй саналын томьёолол гаргасан байгаа. Саналын томьёоллыг танилцуулъя. Ажлын хэсгийн ахлагч Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

**Б.Пүрэвдорж:** Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.5 дахь хэсгийн “энэ хуулийн 34.6-д заасан журмын дагуу тооцож, төрийн дансанд байршуулна.” гэснийг ажлын хэсгийн гишүүд ярилцаад, чиглэл авсны дагуу “олон улсад нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагын санхүүгийн хэрэгсэл ашиглах, эс үгүй бол Монголбанк дахь валютын тусгай дансанд байршуулах бөгөөд гагцхүү зориулалтын дагуу ашиглана.” гэж санал гаргаж байна.

Тэгээд энэ саналын дагуу. Тэгэхээр энэ дээр яах вэ, Төрийн сангийн данс дээр байршуулах тухай асуудал яригддаг. Гэхдээ энэ Төрийн сангийн данс дээр байршуулах юм бол яг л Төрийн сан дээр жишээ нь ЭМД-ын сангийн мөнгө, Нийгмийн даатгалын сангийн мөнгө очоод л ер нь ингээд төсвийн зарцуулалтад ингээд татагдаад явдаг. Ийм зүйл өнгөрсөн хугацаанд гарсан.

Тэгэхээр ер нь энэ Төрийн сангийн дансанд байршуулах юм бол илүү одоо төрийн төсвийн төсөвт татагдаж зарцуулагдах магадлал маш их өндөр байгаа.

Тийм учраас валютын тусгай дансанд байршуулж, гагцхүү зориулалтын дагуу ашиглана гэсэн ийм заалтыг нэмж байгаа. Тэгэхээр ингэсний үр дүнд энэ 1 дүгээрт, Монголбанкны, Монголбанканд тусгай дансанд байршуулсны үндсэн дээр лэйбордоор нэмэх нь ойролцоогоор нэг 1 хувийн шимтгэл төлж байгаа. Юу хүү төлнө. Тэр хүү төлөх дээр нэг ойролцоогоор 13 сая доллар гэхээр нэг жилдээ нэг 600 мянган доллароор энэ сан нь арвижаад явах ийм боломжийг бүрдүүлж байгаа юм.

Тэгэхээр ер нь Монголбанк бол Төрийн сангийн нэгдсэн данс гэдэг ийм зүйлийг өнөөдөр Энхтайван дэд ерөнхийлөгч яриад байна. Тэгэхээр энэ дээр би яг тухайн үед даргын үүрэг чиглэл өгсний дагуу Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэнг дуудаж уулзсан. Тэгэхээр ер нь яах вэ, Монголбанкны тус валютын тусгай дансанд олон олон мөнгө байршилдаг. Ялангуяа Хадгаламжийн даатгал банкнууд, дээрээс нь жишээ нь гэхэд Грек бяслаг МАА-н төслийн 306 сая доллар хүртэл Монголбанкны валютын дансанд асуудалгүй хадгалагдаад л байж байгаа.

Тэгэхээр энэ дээр яг энэ валютын тусгай дансандаа байршуулаад, тэгээд тэндээсээ зөвхөн гарц зориулалтын дагуу ашиглана гэдэг Уянгахишиг гишүүний гаргасан энэ саналыг нэмээд, энэ санал хураалгаж өгнө үү гэж Байнгын хорооны дарга нараас хүсэж байна. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Зарчмын зөрөөтэй саналын томьёолол гаргаж байгаа гишүүд Пүрэвдорж гишүүн,

**Б.Пүрэвдорж:** Пүрэвдорж, Батнайрамдал, Анар, Уянгахишиг гишүүн.

**Г.Тэмүүлэн:** 4 гишүүн гаргаж байгаа юм байна. Ингээд Пүрэвдорж гишүүний уншсан саналын томъёоллоор 34.5 дахь хэсгийг санал хураалт явуулъя. Саяын зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцоноос 9 гишүүн дэмжиж, 60 хувиар дэмжигдлээ.

Ингээд Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганд танилцуулах байгаа. Танилцуулах гишүүн байгаа юу. Сүмбээ гишүүн яах вэ, та танилцуулах уу? Тэгье. Батсүмбэрэл гишүүн танилцуулъя.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

14.07 цаг

Ингээд Улсын Их Хурлын гишүүд болоод ажлын хэсгийнхэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ